

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

IX АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Халим хэмээх гайхамшиг

Сэтгүүлч Б.Батбилэг нэгэн сонирхолтой аялалд оролцсон юм. Аяллын нэр нь “Монгол Хемингуэй”. Тэрбээр Японы халим судлалын экспедицэд оролцож Номхон дөлгөөн далайд хэдэн сарын турш халимтай хөөцөлджээ. Энэ бол монгол хүний хувьд халимын араас явсан анхны тохиолдол байлаа. Б.Батбилэг аяллаас буцаж ирээд “Халим гэдэг амьтан чинь...” хэмээх бэсрэг ном бичжээ. Ном “гардуулах” үеэр аяллын тухай болон халимын талаар удтал хөөрөлдсөн нь мэдээж юм. Б.Батбилэгийн яриа, ном хоёр доорх найрууллын маань үндэс болсон билээ.

Далай тэнгисээс хол нутгийн монголчууд бид халимыг том биетэй загас гэж бодох нь олонтоо. Угтаа бол халим нь загас биш харин хөхтөн амьтан юм. Загалмайгаар амьсгалахгүй уушигараа амьсгална. Түрс биш амьд зулзага төрүүлнэ. Түүнийгээ хөхөөрөө өсгөнө. Халимын өвөг дээдэс 55-65 сая жилийн өмнө хуурай газарт амьдарч байсан ноомой нэгэн “гөрөөчин” байжээ. Төрх нь чонорхуу юм. Манай дэлхий дээр олон галав юүлсэн гэдэг. Нэг удаагийн галав юүлэлтээр эх газар хувхайрчээ. Харин дэлхийн бөмбөрцгийн гуравны хоёрыг эзлэн цэлэлзэх далай тэнгис баян байлаа. Халиман чоно “Алтан загасны өвгөн” лугаа адил уснаас салахаа байлаа. Далай тэнгисийн нялцгай биетэн түүний хувьд хэнтэй ч булаацалдахгүй бэлэн хоол байсан юм. Сая сая жил өнгөрөхөд хөл нь бараг сэлүүр болж хувирлаа. Усанд амьсгаа авахгүйгээр гурав, дөрвөн минут, бүр гучин минут байж хоолоо олж чаддаг боллоо. Ийнхүү халим цэнхэр далайн сая сая жилийн бүтээгдэхүүн болон хөгжиж иржээ.

Одоо дэлхий дээр 80 гаруй зүйлийн халим амьдардаг байна. Далайн мандал дээр гарч ирээд усан хуй үлээж байгаа нь сүртэй гэж. Яг л орсон буур шиг. Хамгийн аварга нь цэнхэр халим. Нөгөөтэйгүүр цэнхэр халим манай дэлхийн хамгийн том амьтан юм. Биеийн урт нь 25-30 м, жин нь 90-120 тонн, зулзага нь 7-8 м урт, хоёр тонн орчим жинтэй төрдөг гэхчлэн гайхамшигт тоо цувруулж болох юм. Гэхдээ тоо заримдаа юуг ч илэрхийлж чаддаггүй. Халимын оврыг ерөнхийд нь ойлгуулах гэвэл гурван орцтой хоёр давхар орон сууцтай зүйрлэхэд дөхнө. Эсвэл түүний судсаар нь хүн хөвөөд явчуйц гэж яривал илүү ойлгомжтой болох билээ. Халим ерөнхийдөө “Алатау” үүлдрийн үнээтэй төстэй, нуруугаараа бор саарал, хэвлийгээрээ цагаавтар өнгөтэй юм билээ. Цэнхэр халим уснаас гарч ирэхдээ цэнхэр туяа цацруулдаг учир ингэж нэрлэсэн болохоос цайвар саарал зүстэй амьтан ажээ.

Цэнхэр халим Номхон их далайд нүүдэллэн амьдардаг байна. Эрэгт бараг дөхдөггүй. Дулааны улиралд Мексикээс Хойд мөсөн далайн Чукотскийн тэнгис хүртэл аялан очиж үр зулзагаа гаргадаг байна. Халим ганц тугал гаргана. Чукотскад зуссан халим өвлийн эхээр зулзагаа дагуулсаар өмнөдийн дулаан тэнгис рүү 16-22 мянган км замыг туулан ирж өвөлждөг.

Хамгийн том амьтны идэш хариугүй бяцхан өт хорхой нялцгай биетэн байдаг нь хачирхалтай. Аварга халим далайн гүн рүү шумбаж байснаа эргэж дээшээ харна. Хэсэг өт хорхой олж дээш нь тууна. Тэд нь босож байгаа хуй шиг замдаа тааралдсан бүгдийг хаман өтгөрч дээшээ зугтсаар л байна. Мандал дээр гармагц нь устай юутай хээтэй нь залгиж орхино. Халим байсхийгээд л ус цацруулж эхэлдэг нь залгисан усаа хамрынхаа нүхээр гадагшлуулж буй хэрэг юм. Усаа цацруулж аманд үлдсэн хоолоо залгиж дууссаны дараа дахин гүн амьсгаа авч далайн гүнд шунгана. Халимын ходоод 2,5 тоннын багтаамжтай. Ийм ходоодыг өтөөр дүүргэх гэдэг маш их ажил болох нь ойлгомжтой. Халимууд цадсан үедээ далайн мандал дээгүүр умбан шумбан тоглодог.

Ертөнцөд найм дахь гайхамшиг гэж байдаг бол тэр нь лавтайяа халим байх биз. Хэчнээн эрхэмсэг тансаг амьтан гэж бодно. Цэвэрхэн, тайван амгалан, энэ их далайн эзэн нь би гэх шиг. Бас “Цэнхэр гүнж” гэж өхөөрдөх нь ч бий. Тун оносон нэр шvv. Тийм л гоёмсог сайхан амьтан даа. Цэнхэр их далайдаа амгалан тайвнаар хөвсөөр л. Халим маш сайхан дуу гаргадаг амьтан. Буга урамдаж байгаа юм шиг авиа гаргадаг. Тэр нь нэлээд алсаас дуулдана.

Ертөнцөд найм дахь гайхамшиг гэж байдаг бол тэр нь лавтайяа халим байх биз.

Их далайд хүнээс өөр дайсангүй жаргалтай. Тэрхүү сансар мэт уудам усан огторгуйд хүн ч юу гэж үзэгдэх вэ? Сүрэглэн хөөцөлдөнө. Зулзагаа нуруундаа үүрч эрхлүүлнэ. Дээшээ харвал гэдсэн дээр нь, доошоо харвал нуруун дээр чаргуулдаастай. Эхээс өдөрт 100 литр сүү гарах чадвартай гэсэн. Дээр хөх тэнгэр мэлтийж, доор хөх далай цахарна. Урт насалж удаан жаргана. Гэвч бас нэг зовлон байдгийг мартчихаж. Хааяа өвчин тусна. Давхисаар байгаад эдгээнэ. Хүндэрсэн юм уу шархадсан нэгнээ хоёр талаас нь ээлжлэн өргөж уснаас цухуйлган амьсгалуулдаг ажээ. Эдгэршгүй халдварт өвчин тусвал яах вэ? Шинэ Зеландад 46 эм, 13 эр халим далайн эрэг дээр гэнэт гарч ирээд байсан тохиолдол дэлхий нийтийг шуугиулж байсан цаг саяхан. Иймэрхүү жишээ зөндөө байдаг байна. Чухам юунаас болж ингэж амиа хорлох болов? Олон тайлбар байдаг. Хамгийн үнэнд ойр нь “сүрэгт халдварт өвчин гарсан тул” хэмээх тайлбар юм. Өвчилсөн халимнууд нэгэнт эдгэрэхгүйгээ мэдэрмэгц бусдадаа халдаахгүйн тулд далайн хөвөө зорьдог байна. Далайн ус халдварт өвчнийг агаараас дутахгүй тархаадаг гэнэ.

Ж. Мягмарсүрэн

Даалгавар 1. Зохиолч эхэд ямар асуудлыг дэвшүүлсэн бэ? 2 оноо

Зохиолчийн дэвшүүлсэн асуудал:

Даалгавар 2. Эхийн гол санааг илэрхийлж буй өгүүлбэрийг олж бичээд, яагаад гол санаа гэж бодож байгаагаа эхээс эш татан, өөрийн үгээр тайлбарлаарай. (3 оноо)

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр:

Тайлбар:

Дэвшүүлсэн асуудлын талаар үзэл бодлоо баримтад үндэслэн илэрхийлж, өөрийн санааг дүгнэн бичье.

Даалгавар 3. Дэвшүүлсэн асуудлын талаар үзэл бодлоо бичээрэй. Үзэл бодлоо илэрхийлэх үгсийг ашигласан, тодорхой, бодитой, асуудалтайгаа уялдаа холбоотой байхад анхаараарай. 2 оноо

Миний үзэл бодол:

Даалгавар 4. Өөрийн үзэл бодлоо үнэ цэнтэй, чухал гэдгийг батлах, дэмжих баримтуудыг бичээрэй. 3 оноо

Баримт 1:

Баримт 2:

.....

Баримт 3:

.....

Даалгавар 5. Үзэл бодол түүнийг батлах баримтаа нэгтгэн, санаагаа онцолж товч, тодорхой, ойлгомжтой дүгнэж бичээрэй. 3 оноо

Дүгнэлт:

.....

Даалгавар 6. Давж заалдах шатны шүүх малын хулгайн хэрэгт холбогдогчдын ялыг хэвээр үлдээв” гэсэн өгүүлбэрийн найруулгын алдааг засан сайжруулж бичээрэй. 2 оноо

.....

Даалгавар 7. Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийн хэсгээс уншиж, кирилл бичигт хөрвүүлээрэй. 5 оноо

Мөнхтэнгэгийн үгс

Мөнхтэнгэгийн үгс

Мөнхтэнгэгийн үгс

Мөнхтэнгэгийн үгс

Мөнхтэнгэгийн үгс

.....

Засагч багш нарт:

Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1.5, 2.5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 2 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсон бол 2 оноо

Эхэд дэвшүүлсэн гол асуудлыг олоогүй ч тодорхой хэмжээнд хөндсөн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудалтай хамаагүй зүйл олсон эсвэл асуудлыг тодорхойлоогүй тухай гэж ерөнхийлсөн бол 0 оноо /Цөөхөн үлдсэн мазаалайг хамгаалах тухай гэх биш мазаалайн тухай эм хариулт нь ерөнхий болно/

Даалгавар 2. Нийт 3 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Эхээс эш татан санаагаа батлан тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл эхээс эш таталгүй, өөрийн үгээр бичсэн бол 0 оноо

Даалгавар 3. Нийт 2 оноо

Үзэл бодол нь дэвшүүлсэн асуудалтай уялдаа холбоотой бол 1 оноо

Үзэл бодол нь дэвшүүлсэн асуудалтай холбоо хамааралгүй бол 0 оноо

Үзэл бодлоо илэрхийлэх үгсийг ашигласан бол 1 оноо

Үгсийг ашиглаагүй бол 0 оноо /Мөн даалгавар 1-ийг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 3/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо/

Даалгавар 4. Нийт 3 оноо

Даалгавар 3-т бичсэн үзэл бодолтой хамааралтай бол 1 оноо

Ахин нэг өөр байр сууринаас хандсан бол 0 оноо /хэрэв энд 0 оноо авсан бол баримтыг зөрчилтэйд тооцно/

Өөрийн үзэл бодлыг дэмжсэн, баталсан буюу зөрчилгүй бол 1 оноо

Аль нэг баримт зөрчилтэй бол 0 оноо /өөрийн үзэл бодлын эсрэг, ташааруулж болох, худал зэрэг баримтууд нь зөрчилтэйд тооцогдоно/

Гурван баримт бичсэн бол 1 оноо

Нэг л баримт дутуу бол 0 оноо /Мөн даалгавар 1, 3-ыг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 4/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо/

Даалгавар 5. Нийт 3 оноо

Даалгавар 3, 4-ийг хамааруулан нэгтгэн дүгнэсэн бол 1 оноо

Дүгнэлт нь тодорхой бөгөөд ойлгомжтой бол 1 оноо

Дүгнэлтээс асуудлыг шийдэх ямар нэгэн шийдэл, гарах арга зам эсвэл шинэ санаа гарсан бол 1 оноо

Дээрх шалгуурын аль нэгийг хангаагүй тохиолдолд харгалзах оноог хасна. Мөн даалгавар 1, 3, 4-ийн аль нэгийг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 5/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо

Даалгавар 6. Нийт 2 оноо

Өгүүлбэрийн найруулгын алдааг бүрэн төгс зассан бол 2 оноо

Өгүүлбэрийн найруулгын алдааг дутуу хагас зассан бол 1 оноо

Найруулгын алдааг засаагүй, буруу зассан эсвэл өөр шинэ алдаа гаргасан бол 0 оноо

Даалгавар 7. Нийт 5 оноо

Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо

1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

| агуулаа | оноо өгөх заавар | ОНОО |
|--------------------|--|----------|
| Сэдэв ба зорилго | Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол | 5 |
| | Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол | 4 |
| | Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол | 3 |
| | Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол | 2 |
| | Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол | 1 |
| | Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Дүр дүрслэл | Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол | 2 |
| | Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол | 1 |
| | Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Хэв маяг | Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол | 2 |
| | Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/ | 1 |
| | Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Бүтэц | Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол | 3 |
| | Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол | 2 |
| | Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол | 1 |
| | Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Хэл зүй, найруулга | Хэл зүй найруулгын алдаагүй бол | 3 |
| | Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол | 2 |
| | Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол | 1 |
| | Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/ | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Үгийн тоо | 180-210 хооронд бол | 1 |
| | Үгийн тоо их, бага бол | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Зөв бичгийн дүрэм | 0-1 алдсан бол | 3 |
| | 2-5 алдсан бол | 2 |
| | 6-9 алдсан бол | 1 |
| | 10+ бол | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |
| Бичгийн соёл | Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/ | 1 |
| | Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол. | 0 |
| | <i>хийгээгүй бол</i> | X |